

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ  
МЭДЭГДЭЛ, 2023-2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**1.ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:**

**1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:**

“59.7.Энэ хуулийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 5 хувийг тухайн эх үүсвэрийн 20 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймагт тэнцүү хэмжээгээр, 15 хувийг тухайн эх үүсвэрийн 1 ба түүнээс дээш 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймагт бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж, мөн хуулийн 59.1.5-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 30 хувийг тухайн эх үүсвэрийн 1 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймагт тэнцүү хэмжээгээр тус тус хуваарилна.”

**Санал гаргасан: Ч.Хүрэлбаатар, П.Анужин, Т.Аубакир, Ж.Бат-Эрдэнэ,  
Х.Болорчулуун, Х.Булгантуяа, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Д.Ганбат,  
Б.Жаргалмаа, Л.Мөнхбаатар, Ж.Мөнхбат, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг,  
Н.Наранбаатар, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, Б.Пүрэвдорж,  
Ц.Цэрэнпунцаг, С.Чинзориг, Б.Энхбаяр  
/цаашид “Ажлын хэсэг” гэх/**

**2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.55 дахь заалтын “Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрт мөнгөн хуримтлал үүсгэж, хүүхдийн нэрийн дансанд байршуулах зорилгоор” гэснийг “хуримтлал үүсгэх зорилгоор” гэж өөрчлөх.**

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

**3.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“**6 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.55 дахь заалт, 2 дугаар зүйлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал, бусад зүйл, хэсэг, заалтыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

**Санал гаргасан: Ажлын хэсэг**